



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДОА-2023/34/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Чойбалсан хот

2023 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор: М.Ухаанбилэг

Утас: 7058-4207, Цахим хаяг: ukhaanbilegm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....
  - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
4. Аудитын тайлан .....

  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....

5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
Дорнод НАА ОНӨААТҮГ	Дорнод Нийтийн аж ахуй Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРНИЙ АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2023.02.25 № 84

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -г

ДОРНОД АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА П.БАТ-ӨЛЗИЙ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв тогилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

### Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу үнэлсэн нөлөө бүхий эрсдэлтэй, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал үйл явдал гараагүй болно.

### Бусад асуудлын хэсэг

Аймгийн ЗДТГ нь 2022 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 265 заалт бүхий арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 92.1 хувьтай хэрэгжсэн байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж тогилуулах үүрэгтэй.

011020259

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>140,472,235.60</b>	<b>144,339,835.60</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	140,472,235.60	144,339,835.60
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	127,470,235.60	131,720,835.60
35410	Бичиг хэргийн материал	2,544,943.60	205,943.60
35420	Аж ахуйн материал	124,925,292.00	131,514,892.00
35600	Мал амьтад	13,002,000.00	12,619,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>5,604,322,395.19</b>	<b>7,945,275,675.47</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	5,604,322,395.19	7,945,275,675.47
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	5,104,322,395.19	7,445,275,675.47
39201	Барилга, байгууламж, орон сууц	469,911,800.00	469,911,800.00
39202	Хуримлагдсан элэгдэл	(456,261,529.69)	(456,721,824.73)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	608,970,000.00	32,170,000.00
39204	Хуримлагдсан элэгдэл	(474,121,689.70)	(8,712,708.29)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	314,481,679.00	449,471,800.00
39206	Хуримлагдсан элэгдэл	(195,503,481.22)	(198,428,993.14)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	133,326,553.00	181,893,947.00
39208	Хуримлагдсан элэгдэл	(108,872,419.20)	(65,234,296.37)
39214	Бусад үндсэн хөрөнгө	26,656,850.00	26,656,850.00
39215	Хуримлагдсан элэгдэл	(26,656,850.00)	(26,656,850.00)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	4,812,391,483.00	7,040,925,951.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	500,000,000.00	500,000,000.00
39301	Програм хангамж	121,859,618.94	121,859,618.94
39302	Хуримлагдсан элэгдэл	(121,859,618.94)	(121,859,618.94)
39303	Бусад биет бус хөрөнгө	500,000,000.00	500,000,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>5,744,794,630.79</b>	<b>8,089,615,511.07</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>5,744,794,630.79</b>	<b>8,089,615,511.07</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	5,744,794,630.79	8,089,615,511.07
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,124,330,743.83	2,124,330,743.83
51101	Өмч: - төрлийн	2,124,330,743.83	2,124,330,743.83
<b>512</b>	<b>Хуримлагдсан үр дүн</b>	<b>3,600,619,524.76</b>	<b>5,945,440,405.04</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	3,600,619,524.76	3,600,619,524.76
51220	Тайлант үеийн үр дүн	-	2,344,820,880.28
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	19,844,362.20	19,844,362.20
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>5,744,794,630.79</b>	<b>8,089,615,511.07</b>



## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>4,396,932,827.00</b>	<b>6,539,999,092.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БҮС ОРЛОГО</b>	<b>42,268,779.00</b>	<b>327,317,990.00</b>
120	Нийтлэг татварын бүс орлого	42,268,779.00	327,317,990.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	42,268,779.00	327,317,990.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	31,376,961.00	27,317,990.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,891,818.00	300,000,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>4,354,664,048.00</b>	<b>6,212,681,102.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>1,319,169,548.00</b>	<b>1,746,259,602.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээ авсан хандив, тусламж	-	200,000,000.00
131103	ЗГНХ, ЗДНХөрсөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс гухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,027,265,458.00	1,165,731,784.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	291,904,090.00	380,148,838.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	378,980.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>3,035,494,500.00</b>	<b>4,466,421,500.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,815,322,700.00	3,958,932,500.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	1,220,171,800.00	507,489,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>4,396,932,827.00</b>	<b>6,435,826,092.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,396,932,827.00</b>	<b>6,435,826,092.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>4,093,294,180.78</b>	<b>3,814,799,147.27</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,107,197,491.78</b>	<b>1,123,397,193.27</b>
210101	Үндсэн цалин	470,368,642.00	479,799,693.75
210102	Нэмэгдэл	274,668,119.00	195,195,232.05
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	76,812,356.86
210104	Урамшуулал	46,580,418.00	50,268,825.18
210105	Гэрээт ажлын хөлс	315,580,312.78	321,321,085.43
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>133,590,113.00</b>	<b>130,656,002.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	92,423,093.59	88,889,865.24
210202	Тэтгэмжийн даатгал	9,995,462.40	9,980,741.69
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,996,348.29	8,139,816.14
210204	Ажилгүйдлийн даатгал	1,953,187.90	1,985,017.55
210205	Эрүүл мэндийн даатгал	21,222,020.82	21,660,561.38
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>67,586,649.00</b>	<b>54,087,485.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	14,233,919.00	8,998,076.00
210302	Түлш, халаалт	21,231,894.00	18,652,558.00
210303	Цэвэр, бохир ус	12,120,836.00	9,096,851.00
210304	Байрны гүрээс	20,000,000.00	17,340,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>90,648,000.00</b>	<b>140,401,360.00</b>
210401	Бичиг хэрэг	11,128,805.00	44,774,050.00
210402	Тээвэр, шатахуун	42,780,000.00	48,755,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,659,195.00	14,341,010.00
210406	Бага үнэтэй, гургэн элэгдэх, ахуйн эд зүйлс	22,080,000.00	32,531,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>1,320,000.00</b>	<b>1,500,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,320,000.00	1,500,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>72,803,300.00</b>	<b>82,291,700.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,833,300.00	19,994,900.00
210604	Урсгал засвар	44,400,000.00	62,296,800.00
<b>2107</b>	<b>Томилдолт, зочны зардал</b>	<b>69,189,497.00</b>	<b>85,417,980.00</b>
210702	Дотоод албан томилдолт	34,189,497.00	85,417,980.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>68,249,426.00</b>	<b>144,818,206.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	59,397,000.00	137,363,740.00
210803	Даатгалын үйлчилгээ	6,640,100.00	3,577,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	541,326.00	688,466.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	231,000.00	248,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,500,000.00
210807	Газрын төлбөр	1,440,000.00	1,440,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,482,709,704.00</b>	<b>2,052,229,221.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,452,991,404.00	2,031,821,481.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	29,718,300.00	20,407,740.00
<b>211</b>	<b>ХҮҮ</b>	<b>-</b>	<b>1,795,691,200.00</b>
<b>2112</b>	<b>Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр</b>	<b>-</b>	<b>1,795,691,200.00</b>
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	-	1,795,691,200.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>303,638,646.22</b>	<b>825,335,744.73</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>43,379,700.00</b>	<b>24,062,100.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,960,000.00	3,035,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	38,419,700.00	21,027,100.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>260,258,946.22</b>	<b>592,820,676.73</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	260,258,946.22	592,820,676.73
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>0.00</b>	<b>208,452,968.00</b>
213405	Нэмэлт санхүүжилтийн төв шилжүүлэг	-	208,452,968.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>-</b>	<b>104,173,000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>-</b>	<b>104,173,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>-</b>	<b>104,173,000.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	-	104,173,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	104,173,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-</b>	<b>(104,173,000.00)</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D01	2021 оны 12-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,124,330,743.83	19,844,362.20	3,600,619,524.76	0.00	5,744,794,630.79
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,124,330,743.83	19,844,362.20	3,600,619,524.76	0.00	5,744,794,630.79
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайланг үеийн үр дүн	0.00	0.00	2,344,820,880.28	0.00	2,344,820,880.28
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,124,330,743.83	19,844,362.20	5,945,440,405.04	0.00	8,089,615,511.07

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	4,476,421,500	4,200,918,813
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	4,386,421,500	4,123,795,813
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,564,453,200	2,304,042,513
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,162,499,900	1,107,099,553
210101	Үндсэн цалин	511,500,000	479,799,694
210102	Нэмэгдэл	208,422,300	195,195,232
210103	Унаа хоолны хөнгөлөлт	72,000,000	76,812,357
210104	Урамшуулал	52,000,000	50,268,825
210105	Гэрээт ажлын хөлс	318,577,600	305,023,445
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	145,312,600	128,797,557
210201	Тэтгэврийн даатгал	98,812,600	87,031,420
210202	Тэтгэмжийн даатгал	11,625,000	9,980,742
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,300,000	8,139,816
210204	Ажилгүйдлийн даатгал	2,325,000	1,985,018
210205	Эрүүл мэндийн даатгал	23,250,000	21,660,561
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	80,500,000	54,087,485
210301	Гэрэл, цахилгаан	18,500,000	8,998,076
210302	Түлш, халаалт	24,000,000	18,652,558
210303	Цэвэр, бохир ус	18,000,000	9,096,851
210304	Байрны гүрээс	20,000,000	17,340,000
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	165,127,600	140,401,360
210401	Бичиг хэрэг	40,878,100	44,774,050
210402	Тээвэр, шатахуун	75,600,000	48,755,100
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	19,500,000	14,341,010
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	29,149,500	32,531,200
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1,500,000	1,500,000
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000	1,500,000
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	84,494,900	82,291,700
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,994,900	19,994,900
210604	Урсгал засвар	64,500,000	62,296,800
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	85,422,200	85,417,980
210702	Дотоод албан томиллолт	85,422,200	85,417,980
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	159,267,700	142,356,206
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	143,101,000	134,901,740
210803	Даатгалын үйлчилгээ	12,000,000	3,577,100
210804	Тээврийн хэрэгслийн татвар	916,700	688,466
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	250,000	248,900
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,500,000	1,500,000
210807	Газрын төлбөр	1,500,000	1,440,000
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	680,328,300	562,090,672
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	662,870,000	544,777,672
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,458,300	17,313,000
<b>211</b>	<b>ХҮҮ</b>	1,795,691,200	1,795,691,200
<b>2112</b>	<b>Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр</b>	1,795,691,200	1,795,691,200
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	1,795,691,200	1,795,691,200
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	26,277,100	24,062,100
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	26,277,100	24,062,100
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,250,000	3,035,000
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,027,100	21,027,100
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>90,000,000</b>	<b>77,123,000</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	90,000,000	77,123,000
223001	Бусад хөрөнгө	90,000,000	77,123,000
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	4,183,600,823	4,200,918,813
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	4,173,600,823	4,173,600,823
122005	Орон нутгийн төсвөөс	4,173,600,823	4,173,600,823
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	10,000,000	27,317,990.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,000,000	27,317,990

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,537,806,634.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,537,806,634.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,537,806,634.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>16,297,640.00</b>
210105	Гэрээт ажлын хөлс	16,297,640.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>1,858,445.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	1,858,445.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>29,512,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,512,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,490,138,549.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,487,043,809.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,094,740.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,537,806,634.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>1,537,806,634.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	200,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	957,278,816.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	380,148,838.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	378,980.00

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын эрхэм зорилго нь төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэхэд оршино.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газар нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай, Хөдөлмөрийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон холбогдох салбарын бусад хуулиуд, дээд шатны төсвийн захирагчаас ирүүлсэн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлж ажилладаг.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна..

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,344.2 сая төгрөгөөр буюу 71.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Бараа материал	140,472.24	144,339.84	3,867.60
Үндсэн хөрөнгө	5,604,322.40	7,945,275.68	2,340,953.28
<b>Нийт хөрөнгө</b>	<b>5,744,794.63</b>	<b>8,089,615.51</b>	<b>2,344,820.88</b>
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	5,744,794.63	8,089,615.51	2,344,820.88
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>5,744,794.63</b>	<b>8,089,615.51</b>	<b>2,344,820.88</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 3,867.6 мянган төгрөгөөр өссөн нь орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа материалын шинжтэй худалдан авалт хийсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өссөн нь дуусаагүй барилгын өртгийг тайлант онд санхүүжүүлсэн дүнгээр 2,228,534.4 мянган төгрөгийг, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 116,286.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авалт хийсэнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,638.0 сая, үйл ажиллагааны орлогоос 10.0 сая, нийт зарлагыг 2,638.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 474.9 зардлыг мянган төгрөгөөр бууруулж, 2,163.2 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,153.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс 10.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 2,135.9 сая төгрөгийн, нөөцийн сан 507.4 сая төгрөгийн, дотоод зээлийн үйлчилгээний төлбөр 1,795.6 сая төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 27.3 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,785.6 сая төгрөг буюу 86.4 хувьтай байгаа нь оны эцэст Дорнод НАА ОНӨААТҮГ-аас зээлийн төлбөрт 300.0 сая төгрөгийн, үндсэн үйл ажиллагааны зардлаас 292.8 сая төгрөг хэмнэгдэж төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

*/Мянган төгрөгөөр/*

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагаа	4,378,421.20	3,785,600.40	592,820.68	86.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засгийн газрын нөөц сангаас 1,165.7 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 380.1 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого 0.3 сая төгрөг, засгийн газрын шагнал 200.0 сая төгрөг, нийт 1,746.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлсэн.

Үүнээс цалинд 18.1 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 1,490.1 сая төгрөгийг, бусдаар гүйцэтгүүлэх үйл ажиллагаанд 29.5 сая төгрөгийг зарцуулж, үүнээс 208.4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааны тайлагналт, ил тод байдлыг сайжруулахтай холбоотой шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор М.Ухаанбилэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер И.Сэмжидмаа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 2/177 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас 6,343.0 сая төгрөгийн 1 хувиар буюу 63.4 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор үр ашиггүй зардал гаргахгүй ажиллахад анхаарч нийт 801.2 сая төгрөгийг урсгал зардлаас хэмнэж төсөвт төвлөрүүлж ажилласан байна.

Энэ хуулийн хүрээнд 1 орлогч болон 1 зөвлөхийн орон тоог хассанаар 11.2 сая төгрөгийн цалинтай холбоотой зардлын хэмнэлтийг бий болгосон байна

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газар нь 2022 онд шилэн дансны цахим сайтад байршуулах 161 мэдээллийг бүрэн байршуулж ажилласан байна. Ингэхдээ Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-т заасан сар улирлын мэдээ, “6.1.3.дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор;”, “6.1.4.жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор;” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллахгүй хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь:

Цаашид анхаарч ажиллах зөвлөмж өгөв.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр, бараа,

ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 263.0 сая төгрөгийн зөрчил 3 албан шаардлага, 1 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	3	64,795.8	3	64,795.8	100%
Зөвлөмж	1	198,200.0	1	198,200.0	100%
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>262,995.8</b>	<b>4</b>	<b>262,995.8</b>	<b>100%</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар туслах үйл ажиллагаатай холбоотой орлого, зардлыг үзэх шаардлагатай.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 12.9 сая төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс 5.6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 7.3 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлээ.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 5.1 Төлбөрийн акт

- ЗДТГ-ын даргын 2022 оны Б/118 дугаартай тушаалаар 7 албан хаагчдад тус бүр 2.0 сая төгрөгийн шагналт цалин олгосон. Энэ нь Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид шагнал олгох журам”-ын “3.3.Мөнгөн шагналыг төрийн онцгой чухал буюу онц төвөгтэй албан даалгавар биелүүлсэн, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн албан хаагчид олгож болно. Байгууллагын удирдлагын шийдвэрээр тухай ажилтныг шагнах мөнгөн шагналын хэмжээ нь үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл хэмжээтэй байна.” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоов.

## 5.2 Албан шаардлага

- ЗДТГ газар нь зарим удирдах албан тушаалтнуудын цагийн бүртгэлийг хөтөлдөггүй, цаг бүртгэлийг түүвэрлэн үзэхэд нийт ажлын 245 өдрөөс 140 өдөр нь цаг бүртгэл хийгдсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн “13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.” гэсэн заалттай нийцэхгүй мөн санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул цаашид албан хаагчдын цагийн бүртгэлийг хөтөлж ажиллах албан шаардлага хүргүүлээ.
- ЗДТГ нь туслах үйл ажиллагааны зардалд төсвөөс 7.3 сая төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн “44.3.Үндсэн үйл ажиллагааны зардлаас туслах үйл ажиллагаанд зориулж шууд болон шууд бусаар хөрөнгө зарцуулахыг хориглоно.” гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул цаашид уг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

## 5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шагналт цалинг илүү олгосон	1	5,607	1	5,607	-	-	-	-	-	-	-	-
Албан тушаалтнуудын цагийн бүртгэлийг бүрэн хөтөлдөггүй	1	-	-	-	1-	-	-	-	-	-	-	-
Туслах үйл ажиллагаанд төсвөөс хөрөнгө зарцуулсан	1	7,335	-	-	1	7,335	-	-	-	-	-	-
Дүн	3	12,943	1	5,607	2	7,335						

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим сайтад 3 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан	1	-	-	-	-	-	1	-
Дүн	1	-	-	-	-	-	1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
-	-	-	-	-	-	-	-	-
Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой зөрчил								
-	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн	1	-	-	-	-	-	1	-



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2023 оны 02 сарын 05

Утас 23 2111-2023/04/111-СГА-ТШЗ

1111050156

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 6/113 дугаартай тушаалаар 7 албан хаагчдад тус бүр 2.0 сая төгрөгийн мөнгөн шагнал олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид шагнал олгох журам"-ын "3.3.Мөнгөн шагналыг төрийн онцгой чухал буюу онц төвөгтэй албан даалгавар биелүүлсэн, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн албан хаагчид олгож болно. Байгууллагын удирдлагын шийдвэрээр тухай ажилтныг шагнах мөнгөн шагналын хэмжээ нь үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл хэмжээтэй байна." гэсэн зөвлтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн эмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

- Шагналын дагалдах мөнгө болох 5,607,473.00 /Таван сая зургаан зуун долоон мянга дөрвөн зуун далан гурван/ төгрөгийг Дорнод аймгийн Төрийн сан дахь орон нутгийн торгуулийн орлогын 100070000952 тоот дансанд төвлөрүүлэх;
- Актын биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга П.Бат-Өлзий, нягтлан бодогч П.Чимигсүрэн нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТОР

М.УХААНБИЛЭГ

011050156

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын  
2023 оны ... сарын ... өдрийн  
А1170309 ДОА-2023/51/НА/СТА-ТШЗ  
дугаартай төлбөрийн актын хавсралт №1

Урамшуулал хэтрүүлэн авсан албан хаагчдын жагсаалт

№	Нэр	Мөнгөн дүн
1	В.Цэнгэлмаа	367,014.50
2	Х.Соёлмаа	719,937.50
3	М.Арьяазул	719,937.50
4	У.Уранбилэг	812,702.00
5	О.Ганчимэг	922,710.50
6	С.Түвшинбат	1,214,892.50
7	Б.Сувдандарь	850,278.50
Нийт		5,607,473.00

---000---



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оц 06 25

23 20А-2020/34/НА-СТА-Т03

Утас: 7711 3111

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ: Үүнд:

Дорнод аймгийн ЗДТГ нь туслах үйл ажиллагааны зардалд төсвөөс 7,3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3 Үндсэн үйл ажиллагааны зардлаас туслах үйл ажиллагаанд зориулж шууд болон шууд бусаар хөрөнгө зарцуулахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүдээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Туслах үйл ажиллагаанд зориулж 7,335,576.00 /Долоон сая гурван зуун гучин таван мянгэ таван зуун далан зургаан" төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй ажилдаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга П.Бат-Олзий, нягтлан бодогч П.Чимигсүрэн нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

М.УХААНБИЛЭГ

011040004



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 24/20А-2023/34/НА-СТА-ТШЗ

Чойбалсан хот

Г Зөрчил арилгах тухай 7

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

ЗДТГ газар нь зарим удирдах ажилтны цагийн бүртгэлийг хөтөлдөггүй, цаг бүртгэлийг түүвэрлэн үзэхэд нийт ажлын 245 өдрөөс 140 өдөрт нь цаг бүртгэл хийгдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн "13.1. Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно." гэсэн заалттай нийцэхгүй мөн санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Албан хаагчдын цагийн бүртгэлийг хөтөлж ажиллах цаашид уг зөрчлийг давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга П.Бат-Өлзий, нягтлан бодогч П.Чимигсүрэн нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

М.УХААНБИЛЭГ

011040989